

Шинэ түлш

Химичид нефтийн оронд хэрэглэж болох бодис олжээ. Түүний молекулын бүтцийг доор үзүүлэв.

Энэ бодисын молекул нь зөв зургаан өнцөгтийн оройнууд дээр байрлах нүүрстөрөгчийн атомуудаас тогтоно. Уг бодисын шаталтаас үүсэх энергийг нефтээс их болгохын тулд бүх атомын электронгүй болгох шаардлагатай байдаг. Зөв зургаан өнцөгтийн оройнуудыг аль нэг оройноос нь эхлэн нар зөв A, B, C, D, E, F үсгүүдээр дугаарласан. Химичид зөвхөн хөрш хоёр атомд нэг нэг электрон нэмж байрлуулах болон хөрш хоёр атомоос нэг нэг электрон сугалан гарган авах (аль аль атомд дор хаяж нэг электрон байгаа тохиолдолд) гэсэн хоёр үйлдлийг хийж чадна. Атом бүрд анх байсан электронуудын тоо өгөгдсөн бол энэ хоёр үйлдлүүдийг ашиглан ямар ч атомд электрон байхгүй болгож болох эсэхийг олох програм бич.

Input

Эхний мөрөнд тестийн тоо болон N ($N < 100$) натурал тоо өгөгдөнө. Дараагийн N ширхэг мөр тус бүрд хоосон зайгаар тусгаарлагдсан 6 эерэг бүхэл тоо байрлах ба тэдгээр нь харгалзан A, B, C, D, E, F атомд анх байсан электроны тоо болно. Нэг атомд байх электроны тоо 1000-гаас хэтрэхгүй.

Output

Тест бүрийн хувьд атомуудын бүх электроныг сугалан гаргаж болох бол YES, үгүй бол NO гэсэн хариулт хэвлэнэ.

Example

Input:

```
2
1 2 3 1 2 3
1 2 3 4 5 6
```

Output:

```
YES
NO
```